



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

«Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай»

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, Засгийн газрын 2020 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 16.1, 16.2, 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх Авто тээвэр, Авто замын чиглэлээр шалгах хяналтын хуудсыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хавсралтаар баталсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа ашиглахад улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналтын хуудсыг хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ил тод, нээлттэй байлгах, ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Салбарын улсын ерөнхий байцаагч (Х.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Хяналтын хуудас батлах тухай” А/74 дүгээр тушаалын 1, 7, 8, 9, 15, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26 дугаар хавсралтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ЭРЛӨР ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ



142640255